



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.8, "Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам"-ын нэгдүгээр бүлгийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТҮГ-т шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан Төмөр замын тээврийн салбарын холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх, тэдгээрт нийцүүлэн Ажлын хэсгийн ажиллах заавар боловсруулан мөрдөх, төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан тушаалыг үндэслэн гэрчилгээ хэвлэж тамга, гарын үсгээр баталгаажуулан иргэн, хуулийн этгээдэд олгохыг "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТҮГ /А.Буяннэмэх/-т үүрэг болгосугай.

3. "Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам"-д шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах, төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааны гэрчилгээ хүссэн хүсэлтийг зөвхөн цахимаар хүлээн авч шийдвэрлэх ажлыг 2021 оны 2-р сард багтаан эхлүүлэхийг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/, "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТҮГ /А.Буяннэмэх/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг биелүүлэх зорилгоор "Төрийн зарим ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх" гэрээг 1 жилийн хугацаатай байгуулж ажиллахыг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/, "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТҮГ-ын газар /А.Буяннэмэх/-т тус тус даалгасугай.

5. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/81 дүгээр тушаалын дагуу "ГТХЗНТ" УТҮГ-тай байгуулсан "Төрийн зарим ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгэх тухай" 176 дугаар гэрээний хугацаа дууссантай холбогдуулан Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн ажил хүлээлцэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т, гэрчилгээ олгох үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/-т тус тус үүрэг болгосугай.

